



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 5177

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5-ын "а", "г", Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн "Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 39 дүгээр тогтоолын 1.5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан "Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.4.3.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нүхэн жорлонтой сургууль, цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох, техник технологийн шийдэл, ажлын даалгавар боловсруулах, хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: -Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

-Аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга

-Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл мэнд, боловсрол, хүнсний хяналтын хэлтсийн дарга

-Сумын Засаг дарга нар

2. Дээрх үйл ажиллагаатай холбоотой судалгаа, мэдээлэл боловсруулан тухай бүр танилцуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны ажлын хэсэгт санал хүргүүлж, дэмжлэг авах талаар хамтран ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100166